



Өвөрхангай аймгийн Засаг даргын дэргэдэх
Статистикийн хэлтэс

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ-2017



Арвайхээр хот
2017 он

Агуулга

❖ Судалгааны зорилго	
❖ Судалгааны агуулга.....	2
1. Хүн амын тоо, нас, хүйсийн бүтэц.....	3
1.1 Суурин хүн амын тоо, Хөдөлмөрийн насны хүн ам /насны бүтэц, сумаар/	
1.2 Хүн ам зүйн зарим үзүүлэлтүүд	
2. Хөдөлмөрийн зах зээлийн үзүүлэлтүүд.....	5
2.1 Хүн амын ажил эрхлэлт, мянган хүнээр	
2.2 Ажиллах хүчний зах зээл, ажилгүйдлийн түвшин	
2.3 Хангайн бүсийн аймгуудын хөдөлмөр эрхлэлт	
3.Ажиллагсад.....	7
3.1 Ажиллагсдын тоо, эдийн засгийн салбарын ангиллаар	
3.1 Ажиллагсдын тоо, насны бүлгээр	
3.2 Аймгийн албан бус сектор дахь ажиллагсдын тоо, хүйс, насны бүлэг, байршлаар, 2017 оны байдлаар	
4.Ажилгүйчүүд.....	9
4.1 Хангайн бүсийн аймгуудын ажилгүйдлийн үзүүлэлтүүд	
4.2 Ажилгүйдлийн түвшин	
5. Эдийн засгийн идэвхгүй хүн ам.....	11
5.1 Эдийн засгийн идэвхгүй хүн ам, шалтгаанаар	
Дүгнэлт.....	13
Ашигласан материал, номзүй.....	14
Хүн амын хөдөлмөр эрхлэлтийн бүтэц.....	15

Судалгааны агуулга, зорилго

Хөдөлмөр эрхлэлтийн талаарх аймгийн мэдээ, мэдээлэл, статистик тоо баримтуудыг ашиглаж, өнөөгийн хөдөлмөр эрхлэлтийн байдал ямар түвшинд байгааг судлах, аймгийн хүн амын ажил эрхлэлт, ажилгүйдлийг нас хүйстэй нь уялдуулан судалж ажил эрхлэлтийг эдийн засгийн салбарын ангилалаар харуулан, хүн ам зүйн ачаалал, ажил эрхлэлт, ажилгүйдлийн түвшин зэрэг үзүүлэлийг тодорхойлон харуулахыг зорьлоо.

Хамрах хүрээ

Ажиллах хүчний судалгаагаар хүн амын хөдөлмөр эрхлэлтийн талаарх бодит тоон мэдээллийг улсын хэмжээнд болон бүс нутаг, аймгийн түвшинд тооцож тодорхойлно.

Мэдээлэл цуглуулалт

Судалгааны асуулга нь 8 бүлэг, 142 асуултаас бүрдэж байгаа бөгөөд судлаач сонгогдсон өрхөд очиж 15, ба түүнээс дээш насны гишүүн бүртэй нэг бүрчлэн уулзаж, ярилцлага хийх замаар мэдээллээ цуглуулсан.

Мэдээлэл боловсруулалт

Өрхөөс ярилцлага авч, цуглуулсан мэдээллийг зааврын дагуу шалгаж, кодлон компьютерт програм шивэн оруулах, шалгах, засвар хийсний дараа төвд дамжуулах ажлыг аймгийн хэмжээнд статистикийн хэлтсийн ажиллах хүчний судалгаа хариуцсан ахлагч, судлаач нар хийж гүйцэтгэсэн.

Ажиллах хүчний судалгааны мэдээллийг компьютерт шивж оруулах, шалгах, засварлахад тооллого, судалгааны мэдээлэл боловсруулдаг CPro 7.0 багц програмыг, бэлэн болсон мэдээллийн үр дүнг боловсруулж статистикийн дүн шинжилгээ хийж, судалгааны боловсруулалтын үр дүнг хянах, илэрсэн алдааг засварласны үндсэн дээр судалгааны үр дүнгийн хүснэгтүүдийг боловсруулан ажиллаж байна.

I.Хүн амын тоо, нас, хүйсийн бүтэц

Улс, аймгийн эдийн засгийн хөгжил иргэдийнх нь аж байдал, амьжиргааны ерөнхий түвшин нь хүн амынхаа ажил эрхлэлтийн түвшинтэй зохих ёсоор холбоотой байдаг. Ажиллах хүч, ажил эрхлэлтийн байдал нь хүн амын насны бүтцээс шууд хамааралтай байдаг учраас аймгийн хүн амын нас, хүйсийн бүтцийг авч үзье.

2017 оны жилийн эцэст аймгийн хүн ам 115.6 мянгад хүрсний 50.2 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.

Хүснэгт 1. Суурин хүн амын тоо, Хөдөлмөрийн насны хүн ам, насны бүтэц, сумаар, 2017он

Сумын нэр	Бүгд	Эм	0-14		15-59		60+		Хөдөлмөрийн насны хүн ам
			Эм	Эм	Эм	Эм			
Баян-Өндөр	3816	1909	1112	562	2369	1146	335	201	2369
Бүрд	2951	1436	849	418	1846	880	256	138	1846
Бат-Өлзий	7499	3771	2443	1230	4693	2336	363	205	4693
Баруунбаян-Улаан	2803	1400	901	448	1754	868	148	84	1754
Баянгол	3939	1961	1109	549	2579	1252	251	160	2579
Гучин-Ус	2195	1093	638	313	1419	695	138	85	1419
Есөнзүйл	3115	1516	927	441	1939	930	249	145	1939
Өлзийт	2446	1203	720	350	1493	724	233	129	1493
Зүүнбаян-Улаан	4066	1977	1208	600	2592	1238	266	139	2592
Богд	5626	2773	1854	871	3509	1750	263	152	3509
Нарийнтээл	3663	1806	1027	495	2418	1189	218	122	2418
Сант	3644	1786	1073	493	2312	1145	259	148	2312
Тарагт	3373	1642	949	483	2183	1029	241	130	2183
Төгрөг	2764	1371	849	414	1755	862	160	95	1755
Уянга	9512	4750	2967	1435	6063	3004	482	311	6063
Хайрхандулаан	3518	1728	1023	493	2250	1096	245	139	2250
Хужирт	6751	3336	2024	967	4145	2025	582	344	4145
Хархорин	12516	6270	3519	1710	7897	3932	1100	628	7897
Арвайхээр	31487	16368	9701	4756	19621	10290	2165	1322	19621
Бүгд	115684	58096	34893	17028	72837	36391	7954	4677	72837

Аймгийн хүн амын тоо 2017 оны жилийн эцсийн байдлаар 115684 болж, өмнөх оныхоос 1773 хүнээр буюу 1.5 хувиар өсчээ. Нийт хүн амын 30.2 хувийг 15 хүртэлх насны хүүхэд, 63.0 хувийг 15-59 насныхан, 6.8 хувийг 60 түүнээс дээш насныхан эзэлж байна. Өмнөх онтой харьцуулахад 15 хүртэлх насны хүн амын эзлэх хувь 0.4 пунктээр, 60 түүнээс дээш насны хүн амын эзлэх хувь 0.1 пунктээр өсч, 15-59 насны хүн амын эзлэх хувь 0.4 пунктээр буурчээ.

Хүснэгт 2. Хүн ам зүйн зарим үзүүлэлтүүд

Он	Өрхийн тоо	Хүн амын тоо	Жилийн дундаж өсөлт	Нэг өрхөд ногдох хүний тоо	Хүйсийн харьцаа	Хүн ам зүйн ачаалал
2013	32421	111824	1.2	3.44	98.9	54.5
2014	33015	112591	0.7	3.41	99.1	55.3
2015	33275	112774	0.2	3.39	99.3	51.4
2016	33540	113911	1.0	3.40	99.2	52.0
2017	34150	115684	1.5	3.39	99.1	52.8

Аймгийн нэг өрхөд 3.39 хүн ногдож, хүн амын хүйсийн харьцаа 99.1, хүн ам зүйн ачаалал 52.8 байна. Өнгөрсөн оноос хүн ам зүйн ачаалал 0.8 пунктээр өсч, нэг өрхөд ногдох хүний тоо 0.01 пунктээр, хүйсийн харьцаа 0.1 пунктээр тус тус буурсан байна.

II. Хөдөлмөрийн зах зээлийн үзүүлэлтүүд

2008 оноос Ажиллах хүчний түүвэр судалгааны үр дүнгээр хөдөлмөрийн статистикийн үзүүлэлтүүдийг үндэсний хэмжээнд болон аймаг, бүсээр тооцон гаргаж байна. Энэхүү судалгаа нь олон улсад мөрдөж буй нийтлэг тодорхойлолт, арга зүйн дагуу хүн амын эдийн засгийн идэвхийг сүүлийн 7 хоног буюу тухайн үеийн, сүүлийн 12 сарын буюу байнгын идэвхийн аргачлалаар тооцох замаар хүн амын хөдөлмөр эрхлэлтийн байдлыг тодорхойлдог.

Уг судалгаагаар тус аймагт эдийн засгийн идэвхтэй 59.7 мянган хүн байгаагийн 92.4 хувь буюу 55.1 мянга нь ажиллагсад, 7.6 хувь буюу 4.5 мянган хүн нь ажилгүй хүмүүс байна.

Хүснэгт 3. Хүн амын ажил эрхлэлт, мянган хүнээр

	2013	2014	2015	2016	2017
Эдийн засгийн идэвхтэй хүн ам	57.7	54.4	53.4	54.4	59.7
Ажиллагчдын тоо	54.8	52.5	51.4	49.6	55.1
Ажилгүй иргэдийн тоо	2.9	1.9	1.9	4.8	4.5
Ажилгүйдлийн түвшин (%)	5.0	3.5	3.6	8.9	7.6
Эдийн засгийн идэвхгүй хүн ам	16.9	17.8	19.8	17.7	17.7

Өмнөх онтой харьцуулахад ажиллагсдын тоо 11.0 хувиар өсч, ажилгүй иргэдийн тоо 6.3 хувиар, ажилгүйдлийн түвшин 1.3 пунктээр тус тус буурчээ. Эдийн засгийн идэвхгүй хүн амын тоо өмнөх оны мөн үеийнхээс 59 хүнээр буюу 0.3 хувиар өссөн байна. Ажиллагсдын тоо 2017 онд 2015 оныхоос 7.2 хувиар буюу 3.7 мянган хүнээр, 2016 оныхоос 11.0 хувиар буюу 5.5 мянган хүнээр тус тус өсчээ.

Ажиллах хүчний оролцооны түвшин нь хөдөлмөрийн зах зээлийн хөгжил, хүн амын эдийн засгийн идэвхийн байдлыг харуулдаг. Мөн хөдөлмөрийн насны хүн амын хөдөлмөр эрхлэлтийн байдал, эдийн засагт хөдөлмөрийн насны хүн амыг ажлын байраар хангах зорилтын хэрэгжилтийг хянах хэмжүүр болдог. Ажиллагчид болон ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэдийн нийлбэр нь эдийн засгийн идэвхтэй хүн ам буюу ажиллах хүчийг бүрдүүлдэг бөгөөд эдгээр хүн амыг хөдөлмөрийн насны хүн амд харьцуулж ажиллах хүчний оролцооны түвшин (АХОТ)-г тодорхойлдог.

Хүснэгт 4. Ажиллах хүчний зах зээл

	2013	2014	2015	2016	2017
Ажиллах хүчний оролцооны түвшин	79.8	75.3	72.9	75.5	77.1
Хөдөлмөр эрхлэлтийн түвшин	75.7	72.7	70.3	68.8	71.3
Ажилгүйдлийн түвшин	5.0	3.5	3.6	8.9	7.6


Аймгийн ажиллах хүчний оролцооны түвшин нь 2017 онд 77.1 өөрөөр хэлбэл хөдөлмөрийн насны 100 хүн тутмын 77 нь эдийн засгийн идэвхтэй хүн ам байна. Энэ нь өмнөх оноос 1.6 пунктээр өссөн нь хөдөлмөрийн насны хүн амын дотор эдийн засгийн идэвхтэй хүн ам бага зэрэг өссөнийг харуулж байна.

Ажиллах хүчний оролцооны түвшин нь улсын дунджаас 16.0 пунктээр, хангайн бүсийнхээс 6.4 пунктээр их байна.

Хөдөлмөр эрхлэлтийн түвшин нь эдийн засгийн идэвхтэй хүн амын хэдэн хувийг ажил эрхэлж байгаа хүмүүс бүрдүүлж байгааг харуулдаг үзүүлэлт юм. Энэ үзүүлэлт манай аймгийн хувьд 2015 онд 70.3 байсан ба 2016 онд 68.8 болж 1.5 пунктээр буурч, 2017 онд 71.3 болж өмнөх оноос 2.5 пунктээр өсчээ.

Ажилгүйдлийн түвшинг ажилгүй иргэдийн тоог эдийн засгийн идэвхтэй хүн амд харьцуулж тооцдог.

Зураг 1. Ажилгүйдлийн түвшин



Судалгааны дүнгээр ажил эрхлээгүй нийт хүн амаар тооцсон ажилгүйдлийн түвшин аймгийн хэмжээнд 2017 онд 7.6 хувьд хүрч өмнөх оноос 1.3 пунктээр буурсан байна.

Хүснэгт 5. Хангайн бүсийн аймгуудын хөдөлмөр эрхлэлт

Хангайн бүсийн аймгууд	Ажиллагсдын тоо (мян хүн)					Эдийн засгийн идэвхтэй хүн (мян хүн)				
	2013	2014	2015	2016	2017	2013	2014	2015	2016	2017
Архангай	46.2	43.6	40.2	42.4	42.7	48.3	45.3	42.3	44.6	45.2
Баянхонгор	36.3	37.8	39.0	40.0	40.9	39.1	40.0	41.7	45.0	43.3
Булган	27.5	25.3	27.0	25.8	27.4	28.9	28.1	28.3	28.1	30.7
Орхон	31.1	35.4	38.3	33.1	32.2	39.4	40.3	39.1	42.7	42.1
Өвөрхангай	54.8	52.5	51.4	49.6	55.1	57.7	54.4	53.4	54.4	59.7
Хөвсгөл	53.5	48.5	52.7	54.6	56.3	63.0	52.7	56.5	59.6	61.5
Хангайн бүсийн дүн	249.4	243.1	248.6	246.6	254.8	276.4	260.8	261.3	215.2	282.7
Улсад	1103.6	1110.7	1151.2	1147.8	1238.3	1198.3	1206.6	1243.9	1275.6	1357.4

Хангайн бүсийн аймгуудын ажиллагсдын тоог зэрэгцүүлж харахад хамгийн их нь Хөвсгөл аймаг 56.3 мянган ажиллагсадтай хамгийн бага нь 27.4 мянган ажиллагсадтай Булган аймаг байна. Ажиллагсдын тоогоор манай аймаг хангайн бүсийн дүнд 21.6 хувийг, улсын дүнд 4.4 хувийг эзэлж байна.

III. Ажиллагсад

Ажиллах хүчний судалгаа нь хүн амын хөдөлмөр эрхлэлтийн байдлын талаар дэлгэрэнгүй мэдээллийг цуглуулах зорилготой билээ.

Судалгааны үр дүнгээр 2017 онд 55.1 мянган хүн ажил эрхэлж байгаа ба энэ нь өмнөх оноос 11.0 хувиар буюу 5.5 мянган хүнээр өссөн байна. Аймгийн ажиллагсдын 47.3 хувь нь эмэгтэйчүүд байгаа нь өмнөх оноос 0.3 пунктээр өсчээ.

Хүснэгт 6. Ажиллагсдын тоо, эдийн засгийн салбарын ангиллаар

Эдийн засгийн салбарууд	2015	2016	2017	2017/2016
Хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуй	29829	29319	27752	94.6
Уул уурхай, олборлолт	1704	1568	2045	130.4
Боловсруулах үйлдвэр	1510	3087	1889	61.2
Барилга	1808	1144	1953	170.7
Цахилгаан, хий, уур агааржуулалт, усан хангамж	224	347	934	2.7*
Бөөний болон жижиглэн худалдаа	5295	4324	7786	180.0
Зочид буудал, зоогийн газар	886	843	1198	142.1
Тээвэр, агуулах, холбоо	1797	1877	2544	135.5
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	593	350	870	2.4*
Төрийн удирдлага батлан хамгаалах үйл ажиллагаа	1507	1763	2222	126.0
Боловсрол	3260	2924	3009	102.9
Эрүүл мэнд, нийгмийн халамж	1140	1200	1250	104.1
Бусад	1862	837	1729	2.0*
ДҮН	51415	49583	55181	111.3

Тайлбар *-дахин их

Нийт ажиллагсдын тоо 50.3 хувийг хөдөө аж ахуйн салбарт ажиллагсад, 3.7 хувийг уул уурхай, олборлолт, 3.4 хувийг боловсруулах салбарын ажиллагсад, 3.5 хувийг барилгын салбарт ажиллагсад, 1.7 хувийг цахилгаан, дулааны эрчим хүчний салбарын ажиллагсад, 14.1 хувийг бөөний болон жижиглэн худалдаа эрхлэгчид, 2.1 хувийг зочид буудал, зоогийн газрын ажиллагсад, 4.6 хувийг тээвэр, холбооны салбарын ажиллагсад, 4.0 хувийг төрийн удирдлага, батлан хамгаалахын салбарт ажиллагсад, 5.4 хувийг боловсролын салбарт ажиллагсад, 2.2 хувийг эрүүл мэнд, нийгмийн халамжийн салбарын ажиллагсад, 3.1 хувийг бусад салбарын ажиллагсад тус тус эзэлж байна.

Хүснэгт 7. Ажиллагсдын тоо, насны бүлгээр

Үзүүлэлт	2016			2017		
	Бүгд	Үүнээс		Бүгд	Үүнээс	
		Эрэгтэй	Эмэгтэй		Эрэгтэй	Эмэгтэй
Ажиллагсад	49583	26256	23327	55181	29042	26139
15-19	1487	950	537	1975	1416	559
20-24	2986	1907	1079	3042	2135	907
25-29	8238	4113	4125	7290	4212	3078
30-34	7491	3968	3523	7273	3712	3561
35-39	7579	3552	4027	7611	3766	3845
40-44	6284	3620	2665	7909	3358	4551
45-49	5161	2588	2573	8146	3918	4228
50-54	4980	2780	2200	6508	3709	2799
55-59	2885	1488	1397	3157	1711	1446
60+	2494	1292	1202	2270	1105	1165

Насны хувьд ажиллагсдын 13.8 хувь нь 35-39 насны, 14.3 хувь нь 40-44 насны, 14.8 хувь нь 45-49 насны, 13.2 хувь нь 30-34 насны, 13.2 хувь нь 25-29 насны, 11.8 хувь нь 50-54 насны, 5.5 хувь нь 20-24 насны, 3.6 хувь нь 15-19 насны, 5.7 хувь нь 55-59 насны, 4.1 хувь нь 60-аас дээш насны хүн байна.

Хүснэгт 8: Аймгийн албан бус сектор дахь ажиллагсдын тоо, хүйс, насны бүлэг, байршлаар, 2017 оны байдлаар

Бүгд	Үндсэн	Давхар		Үндсэн	Давхар		Үндсэн	Давхар	Хот	Хөдөө
	9287	294		5597	80		3690	214		
20-24	160		Эрэгтэй	160		Эмэгтэй	-		5015	4272
25-29	799			632			167			
30-34	1179	134		776			403	134		
35-39	1659	160		869	80		790	80		
40-44	1855			974			881			
45-49	1578			1186			392			
50-54	855			618			237			
55-59	805			306			499			

60-64	157		76		81
65-69	240		-		240

Албан бус сектор дахь ажиллагчдын үндсэн болон давхар хөдөлмөр эрхлэлтийн байдлыг насаар нь авч үзэхэд 40-44 насныхан үндсэн ажлаараа албан бус хөдөлмөр эрхлэгчид хамгийн өндөр буюу 19.9 хувийг эзэлж байгаа бол эрэгтэйчүүд 45-49 насныхан хамгийн өндөр 21.1 хувь, эмэгтэйчүүдийн хувьд 40-44 насныхан 23.8 хувийг эзэлж байгаа нь хамгийн өндөр байна.

IV. Ажилгүйдлийн түвшин


Хүснэгт 9. Хангайн бүсийн аймгуудын ажилгүйдлийн үзүүлэлтүүд

Хангайн бүсийн аймгууд	Ажилгүйдлийн түвшин					Ажилгүйдлийн тоо /мян.хүн/				
	2013	2014	2015	2016	2017	2013	2014	2015	2016	2017
Архангай	4.4	3.9	5.0	5.0	5.4	2.1	1.8	2.1	2.2	2.5
Баянхонгор	7.3	5.6	6.4	11.2	5.6	2.9	2.2	2.7	5.0	2.4
Булган	4.7	9.7	4.6	8.2	10.7	1.4	2.7	1.3	2.3	3.3
Орхон	21.1	12.3	2.2	22.4	23.5	8.3	4.9	0.9	9.5	9.9
Өвөрхангай	5.0	3.5	3.6	8.9	7.6	2.9	1.9	1.9	4.8	4.5
Хөвсгөл	15.1	7.9	6.7	8.5	8.5	9.5	4.2	3.8	5.0	5.2
Хангайн бүс	9.8	6.8	4.9	10.6	9.8	27.1	17.7	12.7	29.0	27.8
Улсад	7.9	7.9	7.5	10.0	8.8	94.7	95.8	92.7	127.8	119.0

Ажилгүйдлийн түвшин манай аймагт 7.6 хувь, Орхон аймагт хамгийн өндөр буюу 23.5 хувь байна. Манай аймгийн хувьд хангайн бүсийн түвшнээс 2.2, улсынхаас 1.2 пунктээр бага байна.

2017 онд аймгийн хэмжээнд ажилгүйдлийн тоо өмнөх оныхоос 0.3 мянга буюу 6.2 хувиар буурсан байна. Хангайн бүсийн аймгуудтай харьцуулахад Архангай, Баянхонгор, Булган аймгуудын дараа орж, хангайн бүсийн ажилгүйдлийн иргэдийн 16.2 хувийг, улсын хэмжээний нийт ажилгүйдлийн 3.8 хувийг эзэлж байна.

Зураг 2. Ажилгүйдлийн түвшин



V. Эдийн засгийн идэвхгүй хүн ам


Эдийн засгийн идэвхгүй хүн ам 17.7 мянгад хүрч өнгөрсөн оныхоос 59 хүнээр буюу 0.3 хувиар өссөн байна.

Нийт эдийн засгийн идэвхгүй хүн амын 57.9 хувь нь эмэгтэйчүүд, 31.2 хувь нь 15-19 насны, 13.0 хувь нь 50-59 насны, 12.1 хувь нь 30-39 насны, 10.3 хувь нь 20-29 насны, 6.3 хувь нь 40-49 насны хүн ам байна.

Хүснэгт 10. Эдийн засгийн идэвхгүй хүн ам, шалтгаанаар

Үзүүлэлт	2016			2017		
	Бүгд	Үүнээс		Бүгд	Үүнээс	
		Эрэгтэй	Эмэгтэй		Эрэгтэй	Эмэгтэй
Дүн	17687	7257	10430	17746	7469	10277
Гэрийн ажилтай	1770	277	1493	1364	163	1201
Суралцдаг	5531	2532	2999	5420	3053	2367
Тэтгэвэрт	5154	1919	3235	5796	1844	3952
Өндөр настан	872	143	729	156	156	-
Хөгжлийн бэрхшээлтэй	1106	978	128	1921	1205	716
Хүүхэд асарсан	1352	211	1141	1898	81	1817
Өвчтэй байсан	407	205	202	239	160	79
Өвчтөн, өндөр настан асарсан	154	-	154	83	83	-
Бусад	1341	992	349	869	724	145

Зураг 3. Эдийн засгийн идэхгүй хүн ам, шалтгаанаар



Нийт эдийн засгийн идэвхгүй хүн амын 30.5 хувь нь суралцдаг, 0.9 хувь өндөр настан, 10.8 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй, 11.2 хувь нь хүүхэд, өндөр настан, өвчтэй хүн асардаг, 7.7 хувь нь гэрийн ажилтай, 4.9 хувь нь бусад гэсэн шалтгаантай байна.

ДҮГНЭЛТ

Хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлтүүд нь хүн амын насны бүтэц, боловсролын байдлаас шууд хамаардаг бөгөөд хүн амын амьжиргааны түвшин, төрөлт, гэрлэлт, шилжих хөдөлгөөн зэрэг хүн амын үзүүлэлтүүдэд тодорхой нөлөө үзүүлдэг байна.

Хөдөлмөрийн насны хүн амын тоо өсч байгаа нь хүн амын ажил эрхлэлтийг дээшлүүлэх, ажилгүйдлийг бууруулахад онцгой анхаарч ажиллах шаардлага бий болсныг харуулж байна.

Ажиллах хүчний судалгааны үр дүнгээр 2017 онд манай аймагт 55.1 мянган хүн ажил эрхэлж байгаа ба энэ нь өмнөх оноос 11.0 хувиар буюу 5.5 мянган хүнээр өссөн байна. Ажиллагсдын 52.7 хувь нь эрэгтэйчүүд, 47.3 хувь нь эмэгтэйчүүд байна.

2017 онд ажилгүйдлийн түвшин 7.6 болж өмнөх оныхоос 1.3 пунктээр буурсан дүнтэй байна. Энэ нь эдийн засгийн идэвхтэй хүн амын 7.6 хувь нь ажилгүй байгааг харуулж байна. Мөн бүсийн хэмжээнд харьцуулахад Орхон аймаг ажилгүйдлийн түвшин хамгийн өндөр буюу 23.5, Архангай аймаг хамгийн бага буюу 5.4 байна.

2017 оны эцэст ажил эрхлээгүй 4513 хүн байгаагийн 32.7 хувь нь 15-24 насны, 32.4 хувь нь 25-34 насны, 10.4 хувь нь 35-44 насны, 24.4 хувь нь 45-аас дээш насны ажилгүйчүүд байна.

Манай аймгийн ажиллах хүчний оролцооны түвшин 77.1 байгаа нь 2016 оноос 1.6 пунктээр өсчээ.

Судалгааны дүнгээс харахад, ажилгүй иргэдийн тоо 6.2 хувиар буурч, ажиллагсдын тоо 55.1 мянгад хүрч өмнөх оноос 11.0 хувиар буюу 5.5 мянган хүнээр, эдийн засгийн идэвхтэй хүн ам 59.7 мянгад хүрсэн нь өнгөрсөн оноос 9.7 хувиар буюу 5.3 хүнээр тус тус өссөн байна.

Ажиллагчдын ихэнх нь хөдөө аж ахуйн тэр тусмаа мал аж ахуйн салбарт ажиллаж байгаа нь эдийн засгийн бусад дэд салбарыг хөгжүүлэх, аж үйлдвэр тэр дотроо боловсруулах үйлдвэрийн салбарыг түлхүү хөгжүүлэх шаардлагатайг харуулж байна.

Ашигласан материал, номзүй:

1. Хөдөлмөр эрхлэлт,ажиллах хүчний үзүүлэлтийг тооцох аргачлал, түүнийг ашиглах гарын авлага- 2015
2. Ажиллах хүчний судалгааны үндсэн тайлан 2013-2017
3. Хүн амын статистикийн үндсэн үзүүлэлт тооцох аргачлал-2013
4. Аймгийн 2017 оны жилийн эцсийн нийгэм, эдийн засгийн танилцуулга
5. Монгол улсын статистикийн эмхэтгэл-2016
6. Ажиллах хүчний судалгааны үр дүн-2017
7. www.1212.mn
8. www.uvurkhangai.nso.mn

СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙГ ХЭРХЭН АВАХ ВЭ?

Цахимаар:
www.1212.mn
Статистикийн мэдээллийн мэдээллийн сан

www.nso.mn
Энэ сайт нь статистикийн мэдээллийн сангийн үндсэн хэсэг юм. Энэ сайт нь статистикийн мэдээллийн сангийн үндсэн хэсэг юм.

SOCIAL NETWORK
www.facebook.com/Статистик-Мэдээлэл
www.twitter.com/statistic.mn

Утсаар:
Лавлах утас 1900-1212

Учиртай гар утас, таблет ашиглан статистикийн мэдээлэл авах 1212.mn апликаци

1212.mn

uvurkhangai.nso.mn

Өвөрхангай аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс

@stat_uvurkhangai


Нутгийн удирдлагын ордон 403, 417 тоот

70322427, 70323442

uvurkhangai@nso.mn

СТАТИСТИК - ХӨГЖИЛД ХӨТЛӨГЧ ХҮЧ

Хүн амын хөдөлмөр эрхлэлтийн бүтэц



ХЯНАСАН:ХЭЛТСИЙН ДАРГА О.ТҮМЭНЖАРГАЛ

ТАНИЛЦУУЛГА БЭЛТГЭСЭН: МЭРГЭЖИЛТЭН Э.ӨҮЛЭН